



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2021 оны 11 сарын 17 өдөр

Дугаар А/517

Алтай хот

**Ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Агаарын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.5 дахь заалт, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А/479 дүгээр тушаалаар батлагдсан "Агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл хийх журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Агаар бохирдуулах эх үүсвэрийн тоо бүртгэлийн ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: -(Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга)

- Гишүүд:
- (Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн геологи, уул уурхай, байгаль орчин, аялал жуулчлалын хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн)
  - (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга)
  - (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын ой, хүрээлэн буй орчин байгалийн нөөцийн албаны дарга)
  - (Авто тээврийн төвийн дарга)
  - (Мэргэжлийн хяналтын газрын байгаль орчны хяналтын улсын байцаагч)
  - (Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн байгаль орчны шинжилгээний лабораторийн инженер)
  - (Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн байгаль орчны шинжилгээний лабораторийн техникч)
  - (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын орчны бохирдол, химийн бодис хариуцсан мэргэжилтэн)
  - (Сумдын Засаг дарга нар)
  - (Багийн Засаг дарга нар)

2.

-(Сумдын байгаль орчны хяналтын улсын байцаагч)

-(Сумдын байгаль хамгаалагч)

-(Сумдын цаг уурын өртөө, харуулын техникч)

Нарийн бичгийн дарга: -(Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга)

2. Агаар бохирдуулах эх үүсвэрийн тоо бүртгэлийн ажлыг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, үр дүнг 2022 оны 3 дугаар сарын 1-ний өдрийн дотор аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагчид даалгасугай.

ОРЛОГЧ  Г.ЧИНБАТ